



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №33



2018 оны 9-р сарын 17-20

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **1207** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 105(8.7%) галзуугийн эрсдэлд өртсөн, 1075(89%) хачигт халдвар, 12(1.0%) бэтэг, 1(0.1%) хумхаа, 8(0.7%) боом, 6(0.5%) тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын **1075** сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14,5%-иар бага байна.



Онош батлагдсан тохиолдол:


- Хачигт риккетсиоз 798 сэжигтэй тохиолдлын **185(23.2%)**
- Хачигт энцефалитын 183 сэжигтэй тохиолдлын **32(17.5%)**
- Хачигт боррелиоз 93 сэжигтэй тохиолдлын **24(25.8%)**

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт **105** тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 15.3%-иар бага байна. Эпидемиологийн 38-р долоо долоо хоногт эрсдэлд өртсөн тохиолдол нэмэгдэж бүртгэгдээгүй байна.



1.3 Мэрэгч амьтны дуудлага:

Нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, БГД, ХУД, СБД, СХД, ЧД)-ээс мэрэгч амьтны нийт 72 дуудлаганд үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс 12.5%-иар их байна.



Энэ 7 хоногт СХД, БЗД, БЗД, БГД-ээс ирүүлсэн амьтны (тарвага 2 ширхэг) дуудлагад үйлчилж, хураагдсан сорьцыг ЗӨСҮТ-ийн лабораторит шинжилж байна.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Олон улсад:

Mers-CoV халдвар: Саудын Араб улс

Шинэчилсэн мэдээгээр 9 дүгээр сарын 16-ны өдөр тус улсын Riyadh хотод 2, Buraidah хотод 1 Mers-CoV-ын шинэ тохиолдол тус тус нэмж бүртгэгдсэн ба эмнэлэгт хэвтүүлэн эмчилж байна.



Эбола вирус халдвар: Конго улс


Шинэчилсэн мэдээгээр 9 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар тухайн бүс нутагт 142 тохиолдол бүртгэгдсэний 111 тохиолдол нь лабораториор батлагдсан ба 66 тохиолдол нас барсан. Шинээр Beni, Butembo хотуудад 2 шинэ тохиолдол нэмж бүртгэгдсэн байна.



Эх сурвалж: www.promedmail.org

Малын цэцэг өвчин: Оросын холбооны улс /Гордеково, Булгановченски, Амурская муж/

9 дүгээр сарын 18-нд мэдээлэгдсэнээр тус улсын Гордеково, Булгановченски, Амурская мужид хонины цэцэг өвчний тохиолдол бүртгэгдэж сэжигтэй 1100 тохиолдлоос өвчлөлийн түвшин 4.36%-тай /48/ бүртгэгдсэн байна.



Эх сурвалж: <http://www.oie.int>

Тарваган тахал: Мадагскар

9 дүгээр сарын 18-нд мэдээлэгдсэнээр тус улсад тарваган тахлын 8 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс 6 тохиолдол батлагдаж, 2 нас баралт бүртгэгдсэн байна. Нас барсан эхний тохиолдол нийслэл Antananarivo-ын хойд Fiadanana хотод бүртгэгдсэн ба, 2 дах тохиолдол Энэтхэгийн далай дах Ambalavao аралд мэдээлэгдсэн байна. Өнгөрсөн 2017 онд бүртгэгдсэн тарваган тахлын дэгдэлтийн үеэр 1100 гаруй нас баралт бүртгэгдэж байжээ.



Эх сурвалж: www.promedmail.org

